

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баянцагаан соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/72/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033

Цахим хаяг: Narmandakh.ts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805

Цахим хаяг: Erdene.b@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа

Утас: 70357955

Цахим хаяг: Gantuya.o@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	Error! Bookmark not defined.
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	Error! Bookmark not defined.
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	Error! Bookmark not defined.
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Error! Bookmark not defined.
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан.....	4
3.1. Ерөнхий зүйл.....	4
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	4
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	4
3.4. Материаллаг байдал	5
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	5
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	6
3.7. Шилэн дансны мэдээлэл	6
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	7
3.9. Аудитын илрүүлэлт.....	7
Залруулсан алдаа	7
Аудитын зөвлөмж.....	7
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	8
4. Менежментийн захидал	7
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	9

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.05 № 01
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

БАЯНЦАГААН СОЁЛЫН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ С.МӨНХТУЛГА ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Орхон аймгийн Баянцагаан соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Орхон аймгийн Баянцагаан соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Орхон аймгийн Баянцагаан соёлын төвийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

D:\my doc\lalbanbichigt\2019-A4.doc

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Баянцагаан соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч С.Мөнхтулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгадагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгадагч этгээдэд анхан шатны батлагдсан маягтыг бүрэн хөтлөх, үндсэн үйл ажиллагааны орлогыг үндсэн дансанд төвлөрүүлэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Эрдэнэ, аудитор О.Гантуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Баянцагаан соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 01 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон аймгийн Баянцагаан соёлын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Соёл урлагийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймгийн Баянцагаан соёлын төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Орхон аймгийн Санхүү хяналт дотоод аудитын албаны 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил арилгах дараах арга хэмжээг авсан байна. Үүнд:

1. Сар бүрийн санхүүжилтийг төсөв гүйцэтгэл бүлгийн “Цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ” талбарт мэдээлж хэвших,
2. Шилэн дансны дотоод аудитын 2 дугаар улирлын үр дүнг нөхөж мэдээлэх
3. Цаашид цахимаар байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн үнэн зөв байршуулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгснийг

биелүүлээгүй, 5.0 сая төгрөгөөс дээш санхүүжилтийн орлогыг аудитын явцад мэдээллэсэн.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 46,600.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 466.0 мянган төгрөг, гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 95,362.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 953.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Баянцагаан соёлын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,123.1 мянган төгрөгөөр буюу 12.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	70.3		-70.3
Урьдчилгаа			
Бараа материал	10,117.5	11,486.4	1,368.9
Үндсэн хөрөнгө	31,218.2	24,796.5	-6,421.7
Нийт хөрөнгө	41,406.0	36,282.9	-5,123.1
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	41,406.0	36,282.9	-5,123.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	41,406.0	36,282.9	-5,123.1

2019 оны нийгмийн даатгалын шимтгэлийн 70.3 мянган төгрөгийн авлагатай байсныг авч, авлагын данс буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,368.9 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын дансны үлдэгдлээс шалтгаалжээ. Энэ нь оны эцэст уран бүтээлийн зардлаас бүжгийн хувцас, тайз гэрэлтүүлэх лед гэрэл авч тусгай зориулалтын дансанд үлдэгдлээр бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгөд шинээр авсан болон акталсан хөрөнгө байхгүй. Үндсэн хөрөнгө данс тайлант оны 5,123.1 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 95,874.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 1520.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 97,394.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,031.9 мянган төгрөгөөр бууруулж 95,362.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны орлогыг 1520.0 мянган төгрөгөөр төсөвлөсөн ч орлогын төлөвлөгөө батлагдаагүй тул буурсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 95,362.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 95,362.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 95,362.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 99.0 мянган төгрөг, нийт 95,461.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 84,040.0 мянган төгрөгийг зарцуулж 11,421.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 11,421.9 мянган төгрөг буюу 88.1 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 5,099.1 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 1682.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 4185.2 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 18.8 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 137.8 мянган төгрөгөөр, бусад төлбөр хураамж зардлыг 175.9 мянган төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний бусад зардлыг 122.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 99.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, шуудан холбооны зардалд 99.0 мянган төгрөгийг зарцуулсан байна

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 130 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 17 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш 95,362.9 мянган төгрөгийн 12 гүйлгээнээс 58,226.4 мянган төгрөгийн орлогын 6, зарлагын 1 гүйлгээг дутуу мэдээлснийг аудитын явцад мэдээллэж залруулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1		1				
Нийт дүн	1		1				

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 58,318.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 58,226.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 91.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим тайланд 5 сая төгрөгөөс дээш 58,226.4 мянган төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй байсныг аудитын явцад мэдээллэж залруулсан байна.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 91.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бараа материалын тайлан дахь жолоочийн тооцооны хуудасны спидометр болон явсан хүний гарын үсэггүй, тооцоо бодсон нягтлан бодогчийн гарын үсэггүй, анхан шатны баримтыг бүрэн хөтлөөгүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоол, заавар журмын хэрэгжилт хангагдахгүй байх

Өгсөн зөвлөмж:

(ОРА-2021/72/СТА-ТШЗ)

Орхон аймгийн Баянцагаан соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сангийн сайдын 2017 оны 12 сарын 05-ны 347-р тушаалаар батлагдсан зааврын дагуу жолоочийн тооцооны хуудас /НХМаягт ТМ-4/-ыг бүрэн хөтөлж байх.

1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Баянцагаан соёлын төвд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар 2021.02.10-ны 03 тоот албан бичгээр хариуг ирүүлж, хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР



АУДИТЫН ТАЙЛАНГ

Ц.НАРМАНДАХ

Б.ЭРДЭНЭ

О.ГАНТУЯА

Огноо:

Огноо:

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Орхон аймгийн Баянцагаан соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Баянцагаан соёлын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/72/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Орхон аймгийн Баянцагаан соёлын төв	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Анхан шатны маягыг бүрэн хөтлөөгүй.	91.9	Зөвлөмж	Эрхлэгч, нягтлан бодогч	С.Мөнхтулга, Г.Энхзул
	дүн	91.9			

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР



Огноо:

Огноо: